



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgov@audit.gov.mn

2016.11.04 № 01/162

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Я.АЛТАНХУНДАГА ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын газрын 2016 оны гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар **15,482,400.00 /Арван таван сая дөрвөн зуун наян хоёр мянга дөрвөн зуун/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:**

1. Ахмадын сангийн хөрөнгөөр төрийн одон медаль авсан ахмадуудын алдрыг тэмдэглэн 2,436,000.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын 5 /төсвийн хоронгоор шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жисл, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/-т заасныг,

2. Тайлант хугацаанд нийт 13,046,400.00 төгрөгийн түлш шатахууны тооцоо бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлон захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/-т, Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт /автомашины 100 км гүйцэтгэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм мөрдөх/-д заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомжс, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар

190000712

батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон<sup>1</sup> заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай, зориулалтыг дагуу зарцуулж ажиллах;
2. Түлш шатахууны тооцоог бодож баталгаажуулж хэвших,
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Онцгой байдлын газрын төсвийн шууд захирагч /Я.Алтанхундага/, нягтлан бодогч /Б.Төвшинжаргал/ нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

НЯГТЛАН БОДОГЧ  Б.ТӨВШИНЖАРГАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

Онцгой байдлын газрын:



Я.АЛТАНХУНДАГА

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.